

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ: ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ

Доктор, дэд проф. А.АЛТАНЗУЛ

ЛЕКЦИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Хууль тайлбарлаж байгаа учраас хуулийн зүйл, заалтыг бичнэ.
- Хуулийн заалтыг *үгчлэн тайлбарлах* аргаар агуулгыг нь тайлбарлана.
- Зарим хуулийн заалттай холбоотой кейс танилцуулна.
- багшийн лекцэнд дурдаж буй тайлбар, кейсийг Та тараасан Power Point-ийн тэмдэглэх хэсэгт бичнэ.
- Лекцийн агуулгаас асуух зүйлээ АСУУЛТ хэсэгт бичнэ.
- Асуулт гэсэн хэсгийг зохион байгуулагчид өгнө.
- Багш лекцийн дараа асуултыг хүлээн авч хариулна. Бүх оролцогчийн асуултыг хариулах боломжгүй тул Та эмайл хаягаа үлдээнэ үү.

АГУУЛГА



- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ГОЛ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЭТГЭЭД
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА
- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ
- БУСАД ЗҮЙЛ

ЁС СУРТАХУУН

- ХҮН ЮУ ХИЙХ, ЮУНААС ТАТГАЛЗАХ ЁСТОЙГ ИЛЭРХИЙЛНЭ.

Ёс суртахуун

- Юуг хийх боломжтой вэ ? (What I may do?)
- Юуг хийх ёсгүй вэ? (What I must no do?)
- Юуг хийх ёстой вэ? (What I must do?)



“ Хүмүүс олон нийтийн итгэлийг хүлээх үед
тэрээр өөрийгөө нийтийн өмч гэж үзэх ёстой.

”

Т.Жефферсон



Дээд зэргийн ёс суртахууны сахилга бат хийгээд
өөрийгөө үгүйсгэх чанар төрийн албан хаагчдад
байхгүй бол төрийн бүх аппарат илжирнэ

Макс Вебер

- Төрийн удирдлагын ёс зүйн ойлголт нь дан ганц зан үйлдэл биш ёс суртахуунлаг хүн байдаг (Купер).
- Бид ямар төрлийн үйл хийдэг вэ гэдэгт биш, харин бид ямар хүн бэ? гэдэгт анхаарлаа хандуулж, **“хийхэд бус, оршин байх”**-д голлон анхаардаг.
 - Alan Lawton or. Ethics and Management in the Public Sector. (орч.).2013

- Муу юм энэ ертөнцөд хэдий олон ч Муу хүнээс илүү аюул гэж үгүй тул хомхой сэтгэлтэй, шударга бус хүн төр барих эрхгүй.

• *Эрдэнийн эрхи Субашид*

- Энэ цагийн **Алаглагч ноёд, Авилгач түшмэд**, Хариу бодогч өглөгийн эзэд, Тэмцэлдэгч ардаас эхлэн **Суудлын төлөө олох нэр**, Эдийн төлөө номлох ном, Алдрын төлөө үйлдэх буян, Өмгийн төлөө шүтэх шавь тэргүүтэн Муу явдлыг өөрөөр үйлдээд Цагийг муу хэлнэ”

• Данзанравжаагийн “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээх сургааль

- Төрийн болон түшээдийн ёс зүйн уналт нь улс гэр, төр засгаа устахад хүргэдэг тодорхойлогч шалтгаан болдог.

• *Т.Лхагваа, 2017, х.44*

- АЛТАН ШҮДТЭЙ ОРООЛОН ОФФИС, КОНТОРТ
ОЛШРОХООС БОЛГООМЖИЛЖ, ОРЖ ИРЭХ НҮХ СҮВ БҮРТ
НЬ ЕРӨНДӨГ ТАВИУШТАЙ.

• Чой Лувсанжав

Төрийн албан хаагчийн ёс зүйн хуульчлагдаагүй зарчим буюу үнэт зүйлс



Амь биеэ үл хайрлах

- Нийтийн ашиг сонирхлын төлөө хувийн ашиг сонирхлоо хязгаарлуулах, *огоорох*
- Тангарагтаа чин үнэнч байх



Дэлхийн II дайн үед ЗХУ-аас гадаадын Элчин сайд нар Москвагаас холдож, зарим нь нутаг буцаж байхад Ж.Самбуу гуай "Үхэвч сэхэвч хамт" гэж хэлээд үлдсэн.

- *Ш.Сүхбаатар “Монгол төрийн мэргэн өвөө”*




НҮБ-ын хүмүүнлэгийн байгууллагын ажилтнууд Афганистанаас гарахгүйгээр хүүхдийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ үзүүлсээр байх болно гэж мэдэгдсэн.

УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ, ДҮРЭМ

- АНУ-д 1978 онд The Ethics Government Art of 1978 хэмээх эрх зүйн акт гарсан нь төрийн албаны ёс зүйг төдийгүй аливаа ажил, мэргэжлийн ёс зүйг бичмэл хууль, дүрэм буюу төрөөс болон төрийн бүх шатны байгууллага, хуулийн этгээдийн шийдвэрээр баталсан эрх зүйгээр зохицуулдаг практикийн эхлэл болсон гэж үзэж болно.
- 1990 -ээд оны дунд Япон улсад төрийн дээд албан тушаалтнуудтай холбоотой зөрчил, шуугиан их гарч байв. Ёс зүйн хуулийг 1999 онд баталсан.”
 - Баатартогтох, Ц, 2019

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал

1. Авлигаас ангид байх
2. Сонирхлын зөрчил гаргахгүй байх
3. Өөрийн өмч хөрөнгийг мэдүүлж байх
4. Илт хууль зөрчсөн захиргааны шийдвэр гаргахгүй байх
5. Төрийн албаны үнэт зүйлс, эрхэм зорилгод харш үйлдэх гаргахгүй байх
6. Байгууллагын дотоод дүрэм, журмыг сахих, соёлд хүндэтгэлтэй хандах
7. Олон нийтийн өмнө төрийн албан хаагчийн хувиар биеэ зохистой, үлгэр жишээч авч явах, эерэг харилцаа, хандлагатай байх
8. Хүрээлэн буй орчинд ээлтэй, нийтийн сайн үйлст манлайлагч байх

! БИД ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙГ ЗӨВХӨН
ХУВЬ ХҮНИЙ ХАРИЛЦАА, ХАНДЛАГА, БИЕЭ АВЧ ЯВАХ
СОЁЛ ГЭХ АГУУЛГААР ОЙЛГОЖ ИРСЭН.

Тайлбар

НИЙТЛЭГ ШААРДЛАГА	Үйлдэл, эс үйлдэхүй	ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ
АВЛИГААС АНГИД БАЙХ	Авлигын гэмт хэрэг	Эрүүгийн хууль
СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ГАРГАХГҮЙ БАЙХ	Бэлэг авах, давхар ажил эрхлэхийг хориглох, оффшор данс нээх зэрэг захиргааны зөрчил	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
ӨӨРИЙН ӨМЧ ХӨРӨНГИЙГ МЭДҮҮЛЖ БАЙХ	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах захиргааны зөрчил	Авлигын эсрэг хууль
ИЛТ ХУУЛЬ БУС ШИЙДВЭР ГАРГАХГҮЙ БАЙХ	Эрх олгогдоогүй байхад дур зоргоороо шийдвэр гаргах захиргааны зөрчил	Захиргааны Ерөнхий хууль
Төрийн албаны үнэт зүйлс, эрхэм зорилгод харш үйлдэх гаргахгүй байх	Төрийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй, үр ашигтай, чирэгдэлгүй хүргэх, төвийг сахих, ялгаварлан гадуурхахгүй байх улсын болон төрийн байгууллагын нэр хүндийг гутаах аливаа үйлдэл гаргах зэрэг сахилгын зөрчил	Төрийн албаны тухай хуулийн 37, 39

НИЙТЛЭГ ШААРДЛАГА	ҮЙЛДЭЛ, ЭС ҮЙЛДЭХҮЙ	ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ
Байгууллагын дотоод дүрэм, журмыг сахих, соёлд хүндэтгэлтэй хандах	Цаг ашиглалт, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, байгууллагын эд хөрөнгийг хувьдаа ашиглах сахилгын зөрчил, хамт олны дунд бүдүүлэг зан авир гаргах, багаар ажиллахгүй байх зэрэг ёс зүйн дүрэмд заасан зөрчил	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журам Нийтлэг ёс зүйн дүрэм

1. Олон нийтийн өмнө төрийн албан хаагчийн хувиар биеэ зохистой, үлгэр жишээч авч явах, эерэг харилцаа, хандлагатай байх
2. Хүрээлэн буй орчинд ээлтэй, нийтийн сайн үйлст манлайлагч байх ёс зүйн хэм хэмжээг хуулиар зохицуулаагүй

УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ, ДҮРЭМ

- НҮБ-ын Ерөнхий Ассамблей: Нийтийн албан тушаалтны олон улсын ёс зүйн дүрэм
- OECD ийн гишүүн орнуудын төрийн албаны нийтлэг үнэт зүйл
- Европын Зөвлөлийн Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм
- Английн Засгийн газрын сайд нарын ёс зүйн дүрэм
- Канад улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм
- Канадын төрийн үйлчилгээний үнэт зүйл, ёс зүйн хууль
- Япон улсын Нийтийн албаны ёс зүйн тухай үндэсний хууль
- Сингапур улсын төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг үүрэг

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

- 2.1.Энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж

- 3.1.Төрийн албаны хаагчийн ёс зүйн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

- 4.1.Энэ хуулийн үйлчлэлд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /цаашид "төрийн албан хаагч" гэх/ хамаарна.

ТАЙЛБАР



Улс төрийн албан хаагч

ТАХ-ийн 10.1



**Төрийн захиргааны
албан хаагч**

ТАХ 10.2. Яам,
агентлагийн албан хаагч



**Төрийн тусгай албан
хаагч**

ТАХ: 10.3 Шүүгч,
цагдаа



**Төрийн үйлчилгээний
албан хаагч**

ТАХ:10.4: Эмч, багш,
соёл урлаг



4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

-
- 4.2.Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.7, 4.1.9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Тайлбар

- 4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- 4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- 4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- 4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, **төлөөлөгч**;
- 4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Тайлбар

! төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх болон компанийн ажилтанд хамаарахгүй. Эдгээр хүмүүсийн ёс зүйг хэм хэмжээг мэргэжлийн ба байгууллагын дотоод дүрэм, журмаар зохицуулна.

АСУУЛТ 1-17?



5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

- 5.1.1."төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ" гэж төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлагыг;
- **5.1.2."төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил" гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;**
- 5.1.3."төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага" гэж энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ	ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ТУХАЙ ХУУЛЬ
• Ардчилсан ёс, • шударга ёс, • эрх чөлөө, • тэгш байдал, • үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх	1.ард түмэнд үйлчлэх; 2.мэргэшсэн, тогтвортой байх; 3.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх; 4.Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах; 5.төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах; 6.ил тод байх; 7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; 8.захирах, захирагдах ёсыг баримтлах.	• Хүнлэг, энэрэнгүй байх • Үнэнч, шударга байх • Хариуцлагатай байх • Манлайлах • Хамтач байх

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ

- 7.1.1.ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх;
-
- 7.1.2.зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
-
- 7.1.3.хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
-
- 7.1.4.албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх;
-
- 7.1.5.төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх;

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ

- 7.1.6.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх;
- 7.1.7.албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх;
- 7.1.8.байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;
- 7.1.9.албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх;
- 7.1.10.багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах.

ТАЙЛБАР

- ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ БОЛ АЛБАН ХААГЧИЙН УХАМСАР, ЗАН ҮЙЛД ДАДАЛ БОЛОХ ТӨРИЙН АЛБАНЫ ҮНЭТ ЗҮЙЛ, ЗАРЧИМ ЮМ.

! Төрийн албан хаагчийн ёс зүйн хувьд баримтлах зарчим, нийтлэг хэм хэмжээг зөрчсөн гэж тэдэнд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэхгүй. Энэ заалтыг шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлд бичихгүй гэсэн үг.

Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага



ҮҮРЭГ



ХОРИГЛОХ
ЗҮЙЛ

Тайлбар

- Ёс зүйн зөрчил бол энэ хуульд заасан нийтлэг шаардлага буюу хуульд заасан үүрэг, хориглох зүйлийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байна.

Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага

Үүрэг:

- Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

Тайлбар:

- Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг ТАХ-ийн 37 дугаар зүйлд 17 заалт болгон оруулсан.
- АЭХ-ийн 8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.
- 10 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах

- 8.1.1.иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;
- 8.1.2.эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;
- 8.1.3.бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй уг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;
- 8.1.4.бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

- 8.1.5.бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй хязгаарлахгүй байх;
- 8.1.6.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;
- 8.1.7.албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.

Тайлбар 8.1.1.

- Иргэдээс өргөдөл, гомдол ирвэл ИТБАТӨГШТХ-иар хариу өгнө. Энэ хуулиар хариу өгөх үндсэн хугацаа, журмыг нарийвчилан зааж өгсөн. Мөн зарим нарийвчилсан зохицуулалттай хуулинд хариу өгөх хугацааг тусгайлан заасан.
- Харин албан хаагч хуульд заасан шаардлагын дагуу хийх үүргээ биелүүлээгүй, иргэд, хуулийн этгээдийн эрхтэй холбоотой асуудалд тайлбар өгөөгүй, зугтсан үйлдүүд орно. Жишээ нь: иргэдэд тайлбар өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах зэрэг болно.

Тайлбар 8.1.2.

- эрх бүхий байгууллагаас баталсан гэдэг нь хуулиар эрх олгогдсон хууль, эсхүл дүрэмд заасан тохиолдолд хувцаслалтын стандартыг баримтална. Жишээ: тусгай чиг үүргийн байгууллагуудад хамаарна.
- **!** энэ хууль батлагдсантай холбоотойгоор тусгай чиг үүргийн байгууллагууд салбарын дүрэм, журмаа нийцүүлнэ.

Тайлбар 8.1.3.

- ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх: албан үүргээ гүйцэтгэж байхдаа иргэн, хуулийн этгээд, түүнчлэн хамтран ажиллагсдыгаа доромжлох, хараалын үгс хэрэглэхгүй байхыг хэлнэ.
- Жишээ нь: УИХ-ын чуулганы хуралдаанд УИХ-ын гишүүн ёс бус үг, хэллэг хэлэхгүй, зан авир гаргахгүй үүрэг хүлээнэ гэсэн үг.

Тайлбар 8.1.4.

- Бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах гэдэг нь хамтач байх зарчимтай холбогдоно.
- Хууль тогтоох, захиргааны шийдвэр гаргах явцад иргэд, хуулийн этгээд, хамт олныхоо гаргасан санал, зөвлөмжийг үл хүлээн авах, үндэслэлгүйгээр татгалзах зэрэг үйлдүүд орно. Мөн байгууллагын дотоод соёлтой ч энэ заалт холбогдоно.
- Мушгин гуйвуулах гэдэг нь иргэд, хуулийн этгээд, хамтран ажиллагсдын зүгээс тухайн албан хаагчид өгсөн мэдээлэл, шаардлага, тайлбарыг нь өөр агуулгаар тайлбарлахыг хэлнэ.
- Худал мэдээлэл аливаа хэлбэрээр тараах гэдэг нь төрийн болон бусад байгууллага, төрийн албан хаагч, иргэн, хуулийн этгээдийн талаар нотлогдоогүй мэдээллийг цахим, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл амаар, бичгээр тараахыг хэлнэ.

Тайлбар 8.1.5.

- бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрхийг хясан боогдуулах гэдэг нь удирдах түвшний албан тушаалтны ёс зүйн үүрэгт хамаарна.
- Хуульд заасан мэргэшүүлэх сургалт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасан өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдахыг нь үндэслэлгүйгээр хориглох, хүсэлтэд хариу өгөхгүй зэрэг үйлдэл, эс үйлдэхүй орно.

Тайлбар 8.1.6.

Монгол улсын нэр хүндэд халдах үйлдэл гэдэг нь дараах үйлдлүүд орно.

- Сургалт, хэлэлцээрт оролцохгүй байх
- Ажлын уулзалтад хоцорч ирэх
- Тухайн улсын гэмт хэргийн шинжгүй хууль, дүрмийг зөрчсөн тохиолдолд тус улсын хуулиар хариуцлага хүлээсэн ч Монгол улсад энэ хуулиар ёс зүйн зөрчилд давхар хариуцлага хүлээлнэ.

Тайлбар 8.1.7.

- Нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын дагуу НААСЗТХ-ийн заалтыг зөрчсөн шинжгүйгээр албан үнэмлэх үзүүлэх, байгууллагын нэр, албан тушаалын байдлаа бусдад мэдэгдэх замаар өөртөө ашигтай байдлыг бий болгох

Хориглох зүйл

- 8.2.Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах үйл ажиллагааг хориглоно:

- 8.2.1.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах;
- 8.2.2.удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих;
- 8.2.3.хүний эмзэг болон хувийн мэдээллэлээр бусдыг гутаах;
- 8.2.4.албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах;

- 8.2.5.үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох, үйлдэл хийх;
- 8.2.6.соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;
- 8.2.7.албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх;
- 8.2.8.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх.

Тайлбар 8.2.1.

- Төрийн жинхэнэ албан хаагчдын хувьд тангараг өргөдөг ба нийтийн ашиг сонирхлын төлөө төрд чин үнэнчээр зүтгэх зарчмын дагуу зарим тодорхой эрхүүдээ хязгаарлуулдаг. Жишээ нь, улс төрийн намд элсэх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох гэх мэт. Үүнийг ТАХ-д хориглосон. Харин энэ хориглолтыг эсэргүүцэж, жагсаалд оролцохыг уриалах гэх мэт үйлдэл, эс үйлдэхүй орно.

Тайлбар 8.2.2.

- Удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах гэдэг улс төрийн болон удирдах албан тушаалтанд хамаарна.
- Улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах гэдэг нь улс төрийн намын хурал, сонгуулийн сурталчилгаанд удирдлагадаа байгаа албан хаагчийг оролцохыг үүрэг болгох эсхүл санал тавих, түүнчлэн улс төрийн сурталчилгаанд сайн оролцвол төрийн байгууллагын ажил, албан тушаал амлах гэх мэт үйлдэл, эс үйлдэхүй орно.

Тайлбар 8.2.3.

- хүний эмзэг болон хувийн мэдээллэлээр бусдыг гутаах гэдэг нь Хүний хувийн мэдээллийн тухай хуулиар бусдын эмзэг мэдээллийг задруулсан бол Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээнэ. Харин энэ хуульд заасан хориглох зүйл нь нууцыг мэдсэн албан хаагч энэ эмзэг мэдээллийг өөрт болон бусдад хандан гутаан доромжлох үйлдлийг хэлнэ.
- Жишээ: эмч хүн өвчтөний түүхийг мэдсээр байж түүнийг энэ нөхцөл байдлаар нь загнах, тохуурхах зэрэг үйлдлүүд орно.

Тайлбар 8.2.4.

- Төрийн албан хаагчид албан тушаалын тодорхойлолт заасан ажлаа гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөхгүй, шийдвэр гаргахад хамаарах мэдээллүүдийг цуглуулж өгөхгүй эс үйлдэхгүйгээр илэрнэ.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 9.1.1.төрийн албан хаагчийн гаргасан ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг авах;
- 9.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;
- 9.1.3. урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах
- 9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах
- 9.1.5. иргэд, байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, БҮРЭН ЭРХ

- Төрийн албаны Зөвлөлийн дэргэд Ёс зүйн Хороо
- Ёс зүйн дэд хороо
- Томилох эрх бүхий этгээд

Ёс зүйн Хороо

- ТАЗ-ийн 5 гишүүд, орон тооны бус 4 нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Бүрэн эрх

- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих
- Төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шалгаж, дүгнэлт гаргах
- Дэд хорооны журмыг батлах

Дэд хороо

- Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо
- Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд Хороо

Дэд хороо

- Албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- Хугацаа 5 жил
- Албан хаагчдын дундаас сонгогдоно. Даргыг гишүүд дотроосоо сонгоно.

Бүрэн эрх

- 13.3.1.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, **дүгнэлт гаргах**;
- 13.3.2.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- 13.3.3.харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар **зөвлөмж өгөх**;
- 13.3.4.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;
- 13.3.5.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж **Ёс зүйн хороонд хүргүүлэх**;
- 13.3.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

Тайлбар

- Албан хаагчийн талаар гомдол, мэдээллийг хүлээн аваад энэ хууль, нарийвчилсан салбарын хууль болон хуулиар эрх олгосон дүрэмд заасан нийтлэг шаардлагыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргана. Дүгнэлтийн загвар ямар байхыг дэд хорооны журамд нарийвчилан заана. Дүгнэлтийн агуулга нь тухайн албан хаагч зөрчсөн эсхүл зөрчөөгүй, энэ хууль болон бусад салбарын хууль, дүрэмд заасан шийтгэлийн аль хэлбэрийг хэрэглэх тухай бичсэн байна.

! Ёс зүйн дэд хороо нь захирамжилсан шинжтэй шийдвэр гаргахгүй.

Баталгаа

- Урамшуулал
- Хуралдааны үед түр чөлөөлөгдөх
- Дарамт шахалтаас хамгаалуулах

Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх

- 12.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- **12.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах;**
- **12.1.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;**
- 12.1.4.ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороонд гаргаж өгөх;
- 12.1.5.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол ёс зүйн хариуцлага хүлээлгэх;
- 12.1.6.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, Ёс зүйн хороонд тайлагнах;
- 12.1.7.Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;
- 12.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

- Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл гаргах
- Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх

Гомдол, мэдээллийг шийдвэрлэх харьяалал

- 14.3.1.Ёс зүйн дэд хороо өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны;
- 14.3.2.Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан болон Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5, 4.1.9-д заасан этгээдийн;

Гомдол, мэдээллийг шийдвэрлэх процесс

- 15.1.1.гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр, эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тухайн албан хаагчаас биечлэн тодруулга мэдээлэл авах;
- 15.1.2.шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах;
- 15.1.3.шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах;
- 15.1.4.цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;
- 15.1.5.төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, үндэслэлийг тусгах.

АНХААРАХ

- 15.3.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

- 16.1.1.гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;
- 16.1.2.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- 16.1.3.байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;
- 16.1.4. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах

Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээх

- Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.
- 17.2.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;
- 17.2.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.

- 16.5.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.
- 16.6.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.
- Хороо, дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан журмын дагуу тайлан, мэдээлэл гарган дээд шатны байгууллагадаа хүргүүлж, байгууллагын цахим хаягт байршуулна.



БАЯРЛАЛАА

